



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№109 /323/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.06.15

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИ, ЦЭРГИЙН ЦАГДААГИЙН РОТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хяналт, шалгалтын нэгжүүдийн 2022 оны эхний хагас жилийн тайлангийн хурлын үеэр гарсан саналын дагуу Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг өнөөдөр Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Цэргийн цагдаагийн рот болон Зэвсэгт хүчний нэгдсэн лабораторийн үйл ажиллагаа, тулгамдсан асуудлуудтай танилцлаа.

Энэ хүрээнд тус анги, байгууллагын ерөнхий танилцуулгыг сонсож Цэргийн цагдаагийн ротын хичээлийн танхим, эд хэрэгслийн агуулах, Зэвсэгт хүчний нэгдсэн лабораторийн мал эмнэлэг, бактери шинжилгээ, шатахуун, эрүүл зүй, хими, хэмжил зүйн лабораториудын үйл ажиллагаатай танилцан үүрэг чиглэл өгч ажилласан юм.



ГҮЙЛТИЙН ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУД ТОДОРЛОО



ахлагч С.Нандин-Эрдэнэ (350), эрэгтэйчүүдээс Н.Мөнхбаяр (ХХЕГ), ахлагч Ц.Бямбажав (337), Д.Гантулга (ХХЕГ) нар шалгарсан юм. Харин 41-ээс дээш насныхны төрөлд эмэгтэйчүүдээс хошууч Б.Одончимэг (Алдар спорт хороо), дэд хурандаа Х.Эрдэнэтуяа (ТТХГ), Н.Адъяадолгор (119), эрэгтэйчүүдээс Д.Тэмүүжин (ОБЕГ), Д.Цэрэнпил (ЦЕГ), ахлах ахлагч С.Баянмөнх (350) нар эхний байруудад шалгарч, бусдыгаа манлайллаа.

Энэ үеэр Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай "Дэлхийн энх тайван, аюулгүй байдлын төлөө амь биеэ үл хайрлан цэнхэр тугийн дор нэгдэн жагсаж, үүргээ нэр төртэй биелүүлж буй цэнхэр дуулгатнууд болон үе үеийн энхийг сахиулагчид Та бүхэндээ монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, бэхжүүлэх үйлсэд эх орноо төлөөлөн оролцсон цэргийн багууд, бие бүрэлдэхүүнийхээ үйл хэргийг сурталчлах, хүндэтгэл үзүүлэх зорилгоор өнөөдөр бид хамтдаа энэхүү гүйлтийн тэмцээнийг зохион байгуулж байна" гэлээ.

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойн хүрээнд өчигдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд "Эрүүл мэнд-Энхийн төлөө" гүйлтийн тэмцээн нас насны ангиллаар зохион байгуулагдлаа.

Тэмцээнд эмэгтэйчүүдийн 18-30 насны төрөлд тэргүүн байрт ахлагч Б.Мөнхзаяа (327), дэд байрт дэд ахлагч Б.Долгормаа (ХХЕГ), гутгаар байрт Т.Ариунболд (016) нар, эрэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байрт О.Болдоо (ХХЕГ), дэд байрт Д.Мягмарсүрэн (Алдар спорт хороо), гутгаар байрт Н.Жандос (ЦЕГ) нар шалгарав.

Эмэгтэйчүүдийн 31-40 насны ангилалд ахмад Х.Хишигсайхан (Алдар спорт хороо), ахлах ахлагч Ч.Шинэцэцэг (Алдар спорт хороо),



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 26	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	🌧️ 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,123.00	3,127.0
EUR 🇪🇺	3,290.0	3,335.0
CNY 🇨🇳	463.00	467.00
RUB 🇷🇺	48.80	49.20
JPY 🇯🇵	23.20	23.70
KRW 🇰🇷	2.50	2.52

ЗУРХАЙ

2022.06.15 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 16

ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

04.52-20.53

БАРИЛДЛАГА:

Рашаан

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Төрөн түгэхүй

Суудал: Огторгуй

Энэ өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эм, эмнэлгийнэлдэвүйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, сан тавиулах, угаал үйлдэх, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сэвтэй газар очиход муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 541,694,527

Эдгэрсэн

Нийт: 516,861,220

Нас барсан

Нийт: 6,334,113

Цахим шууданд

ЦЭРГИЙН НЭГДҮГЭЭР ЗЭРГИЙН БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНИЙ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тус ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу энэ сарын 5-10-ны өдрүүдэд "Артиллерийн миномётын наводчик", "Зенитийн артиллерийн наводчик", "Тагнуулын салбарчин", "Цэргийн инженерийн хийц угсрагч" мэргэжлээр цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг зохион байгууллаа.

Энэхүү сургалтыг ангийн сургалт, соёл хүмүүжлийн албаны дарга ахмад Б.Энхманлай удирдан явуулсан бөгөөд сургагч багшаар ахлах ахлагч Т.Энхтайван, Ч.Бат-Эрдэнэ нар ажилласан юм.

Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд гэрчилгээ гардуулах ёслолын ажиллагаа энэ сарын 10-ны өдөр болсон бөгөөд БХЯ-ны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга хурандаа Ч.Гандирваа, Баян-



Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Ц.Нацагдорж болон хурандаа У.Буянжаргал захирагчтай Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүн оролцов.

Хурандаа Ч.Гандирваа ёслолын үйл ажиллагааг нээж хэлсэн үгэндээ улс, эх орны бүтээн байгуулалтын ажилд тус анги манлайлан оролцож байгааг цохон тэмдэглээд БХЯ-ны удирдлага болон хувиасаа

ангийн нийт бие бүрэлдэхүүнд амжилт хүслээ. Мөн цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг төлөөлж бэлтгэл байлдагч Л.Давааням үг хэлэн сургалтад хамрагдсан хамт олондоо амжилт хүсэж, сургагч багш нартаа баярласан талархсанаа илэрхийллээ. Үйл ажиллагааны төгсгөлд цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүд хүндэт зочдын хамтаар дурсгалын зураг татуулсан юм.

ТАЕКВОНДОГИЙН СОФИ ГРАН ПРИГААС ...



"Алдар" спорт хороо

Дэлхийн чансааны эхний 16 тамирчин өрсөлдөх эрхтэй, чансаа өндөр Софи гран при тэмцээн Болгар Улсын Софи хотноо энэ сарын 6-10-ны өдрүүдэд анх удаа зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд манай улсаас паратаеквондогийн үндэсний шигшээ баг,

ахлах дасгалжуулагч ахмад Н.Эрдэнэбаатар дасгалжуулагчтай "Алдар" спорт хорооны баг тамирчид оролцов.

Тэмцээний К44 ангиллын эрэгтэйчүүдийн -63 килограммын жинд дэлхийн таван удаагийн аварга Г.Болор-Эрдэнэ хүрэл медаль, К44 ангиллын эмэгтэйчүүдийн -47 килограммын жинд Х.Энхтуяа мөнгөн медаль тус тус хүртлээ.

"ДӨЛ-2022" ТЭМЦЭЭНИЙ II ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТ ЯВАГДЛАА



Ховд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл-2022" цогцолбор тэмцээний хоёрдугаар шатны шалгаруулалтад Жаргалант

сумын I, III, VI, VII сургууль, Булган сумын Минжит Булган цогцолбор сургууль, Алтай, Буянт, Дөргөн, Дуут, Мөст, Мянгад, Чандмань, Үенч сумдын ахлах сургуулийн 13 багийн 170 гаруй баг тамирчин

оролцож 5 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд хурд хүч авхаалж самбаагаар сорин өрсөлдлөө.

Тэмцээний нээлтэд аймгийн Засаг дарга Б.Дүгэржав, Цэргийн штабын дарга хурандаа Б.Ганхуяг,

ХИЛИЙН ЧАНАДААС ОНЦЛОХ БҮТЭЭЛЧ АЖЛАА ТАНИЛЦУУЛАВ



Мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан 20 бүтээлч ажлыг өрнүүлсэн юм. Үүний хүрээнд "Төмөр моторт завь"-ийг зохион бүтээж, бие бүрэлдэхүүнд танилцуулсан нь онцлог үйл явдал боллоо.

Дээрх төмөр моторт завийг батальоны техникийн офицер ахмад Б.Мөнх-Учрал, байлдааны хангалтын ротын захирагч хошууч Г.Уранжаргал нарын санаачилгаар инженер, барилгын салааны сэрээт өргөгчийн оператор дэд ахлагч Т.Батмөнх, гагнуурчин дэд ахлагч Ч.Батмөнх, экскаваторчин

дэд ахлагч И.Мейрамбек, жолооч дэд ахлагч Б.Хангарьд нар зохион бүтээж энэ сарын 5-ны өдөр туршилт хийн ойрын эргүүлийн үүрэг гүйцэтгэв.

Тус завины урт нь 5м, өргөн нь 1,3м бөгөөд 4-10 хүнийг тээвэрлэн 5-30 км/цагийн хурдтай усан эргүүл хийлээ. Мөн үерийн усанд боогдсон хүн, амьтан, эд зүйлсийг татан гаргалтын үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтой. Энэхүү бүтээлч ажил нь мотобуудлагын батальоны мандатад заагдсан үүрэг гүйцэтгэлтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бэлэн байдлын үзлэгт амжилттай шалгуулах нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа давуу талтай юм.

ШИНЭ ТЕХНИКУУДИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ ЭХЭЛЛЭЭ



дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн "Хубилай" баазад шилжүүлэн ашиглалтад оруулаад байна.

Эдгээр техникүүд нь борооны улирлаас өмнө мотобуудлагын батальоны үүрэг гүйцэтгэлтэд чухал ач холбогдолтой бөгөөд ийнхүү НҮБ-ын гэрээгээр хүлээсэн техникийнхээ 23 хувийг шинэчиллээ.

БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багийн техникийг сольж шинэчлэх ажлын хүрээнд 34 нэгж техникийг Монгол Улсаас 2021 оны 10 дугаар сард газраар тээвэрлэн 2022 оны 2 дугаар сард тус улсын нийслэл Жуба хотод хүлээн авсан билээ.

Цагаарын нөхцөл байдал, агаарын тээврийн боломжоос шалтгаалан түр хугацаанд Жуба хотод хадгалалтад байсан дээрх техникүүдийг энэ оны 5



Ахлах дэслэгч П.БАЯЛАГМАА

Биеийн тамир спортын газрын дарга Ч.Түмэндэмбэрэл нар болон тэмцээнд оролцогч сургуулийн захирал, багш дасгалжуулагч, орон нутгийн иргэд, хүүхэд залуучууд оролцов.

Аймгийн Засаг дарга тэмцээний нээлтийн үеэр үг хэлэхдээ энэхүү тэмцээн нь жил бүр уламжлал болон зохион байгуулагдаж байгаа хэдий ч 30 жилийн дараа аймгийн бүх сумдыг хамран зохион байгуулагдаж

байгаагаараа онцлогтой тул баг тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа дайчлан өрсөлдөж Монгол Улсын ирээдүйн Батлан хамгаалах салбарын боловсон хүчин болон бэлтгэгдэх үндэс сууриа сайтар бэхжүүлэхийг уриалж амжилт хүссэн юм.

Аймгийн аварга шалгаруулах тэмцээний нэгдүгээр шатанд баг тамирчид "Жагсаалын үзүүлэх тоглолт", "Гардан тулааны үзүүлэх тоглолт", "Асуулт хариулт",



"Тасгийн захирагчийн тэмцээн", "Гэрийн даалгавар", хоёрдугаар шатанд 6 км маршийн гүйлтээр өрсөлдсөнөөс тэргүүн байрт Жаргалант сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн Н.Энхбаяр захирагчтай тасаг, дэд байрт Үенч сумын ерөнхий боловсролын сургуулийн О.Тэмүүжин захирагчтай тасаг, гутгаар байрт Жаргалант сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн М.Нямлхагва захирагчтай тасгийн хамт олон бусдыгаа хошуучилж амжилттай оролцлоо.

Тэмцээнийг зохион байгуулахад аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, Боловсрол, Шинжлэх ухааны газар, Соёл, урлагийн газар, Биеийн тамир спортын газар болон бусад холбогдох байгууллагууд хамтран ажиллалаа.

Ховд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб